



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МАГАДЛАЛ ХИЙСЭН ТУХАЙ
ДҮГНЭЛТ

2024 оны 06 дугаар сарын 27

Дугаар 272/06-78

Улаанбаатар хот

“ЭМ ЭС ЭЛ” ХХК-д

Нэг. Барилга байгууламжийн зураг төслийн мэдээлэл

1. Барилга байгууламжийн байршил, нэр: Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт орших “Эрдэнэтийн овоо” зэс молибдены хүдэр баяжуулах үйлдвэрийн хүдэр бэлтгэлийн I шугамын технологийг шинэчлэх төсөл”-ийн хүрээнд Том бутлах хэсгийн барилга, Том бутлах хэсгийн туузан конвейерийн дамжуулах станц, Булт нунтаглалтын хэсгийн барилга, Булт нунтаглалтын хэсгийн тэжээлийн конвейерийн дамжуулах станцын барилгын ажлын зураг төсөл

2. Зургийн шифр, зураг төслийн компани: MHI23-EMCO-1100-SD, MHI23-EMCO-1400-SD, MSL-24-04-01, MSL-24-04-02, MSL-24-04-06, MSL-24-04-07, Монхорус интернэшнл ХХК

3. Барилга байгууламжийн зориулалт, захирамж: Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.2-заалт, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэл, Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших MV-000011 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Эрдэнэтийн овоо зэс молибдены ордын баруун хойд, төвийн хэсэгт 2016-2020 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүн, нөөцийн тодотгол тайлан, “Хүдэр бэлтгэлийн I шугамыг шинэчлэх” төслийн техник, эдийн засгийн үндэслэл /Соёолон Инженеринг, 2023/ 06101-2020/00185 дугаартай эзэмшүүлэх гэрээ, Орхон аймгийн ерөнхий архитекторын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 2024/02 дугаар бүхий зураг төсөл боловсруулах даалгавар, загвар зурагтай.

4. Барилга байгууламжийн давхар, талбай: Том бутлалтын хэсгийн барилга 15.80м x 57.00м харьцаатай 3 давхар зоорьтой, Том бутлалтын хэсгийн туузан конвейерийн дамжуулах станц 33.00м x 24.00 м харьцаатай, Булт нунтаглалтын хэсгийн тэжээлийн конвейерийн дамжуулах станц 14.00м x 17.00м харьцаатай, Булт нунтаглалтын хэсгийн барилга 50.00м x 34.00м харьцаатай. Шинэ том бутлах хэсгийн цахилгаан хангамж, Булт нунтаглах хэсгийн цахилгаан хангамж

5. Галд тэсвэршилтийн зэрэг: төлөвлөсөн IIIa,

6. Барилгын үүргийн галын аюулын анги: Ф5, Ф5.1

7. Зургийн иж бүрдэл: 5 хэсэг

Хоёр. Барилга байгууламжийн зураг төслийн
галын аюулгүй байдлын дүгнэлт

1. Барилгын гадна дулаалга болон дүүргэгч материалыг галд тэсвэртэй дулаалгын материалыг ашиглах ба шинжилгээнд оруулсан дүгнэлттэй байх /ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэн/.

2. Холбогдох нормын дагуу автомат бие даасан гал унтраагуурыг цахилгаан хангамжийн гал гарах эрсдэлтэй газруудад төлөвлөх шаардлагатай.

0000~1842

3. Галын дохиоллын мэдээлэгчийн байрлалыг технологийн байгуулалт, дам нуруу, хана, хүртэлх зай, мэдээлэгчийн хүчин чадалтай уялдуулж, өндрийн хэмжээг тооцож галын дохиоллын хэрэгслийг сонгож төлөвлөн түүний дагуу гүйцэтгэх. /БНБД 21-04-05/

4. Гал унтраах даралтын хоолой. Техникийн шаардлага MNS 6576-2016 5.2-ын дагуу галын дотор усны даралтад цэгийн /кран/ хоолойн холболтыг угсарна.

5. Галын дохиоллын хүлээн авагч станцыг хүн 24 цагаар байрлах өрөө тасалгаанд байрлуулах. /БНБД 21-04-05/

6. Гал түймрийн үед нүүлгэн шилжүүлэх гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ, ангилал. Техникийн шаардлага. Хяналтын аргууд MNS GOST R 12.2.143:2013 стандартын дагуу гэрэлтүүлэгч нүүлгэн шилжүүлэлтийн тэмдэг, тэмдэглэгээг хийх.

8. Тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгслийн бүх металл хэсгийг газардуулах нойлын шугам татаж, газардуулгын сүлжээнд холбосон байх.

Гурав. Ерөнхий дүгнэлт

Дээрх шаардлагын дагуу ажлын зургийг засаж, нормын дагуу засвар хийгдсэн зургаар барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах тохиолдолд Онцгой байдлын байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэнэ.

Хянасан: Сар, өдөр	Тэмдэг дарсан хуудасны дугаарууд	Нэмэлт тэмдэглэл
2024.06.27	Нүүр хуудас, ТБХБ: БА 05-14, ХАС 14-22, ЦБУ 5-13, ХД 02-10, ТБХТКДС: БА 23-24, ХАС 05-07, ЦБУ 3-5, ХД 02-03, БНХТКДС: БА 03-06, ХАС 04, ЦБУ 3-5, ХД 02-04, БНХБ: БА 05-07, ХАС 11-13, ЦБУ 6-11, ХД 02-05, ШТБХЦХ: ХТ 6-8, БНХЦХ: ХТ 6-9	Барилгын ажлын зураг төслийг дүгнэлтийн дагуу хийж гүйцэтгэх

ДУГНЭЛТ ГАРГАСАН:
СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН ХЯНАЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН, ДЭД ХУРАНДАА Ч.АРТАГ

